



## ТАХЬКО ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ

(Шинэчилсэн найруулга)

Тахько хувьцаат компанийн энэхүү Дүрэм нь Монгол Улсын Их Хурлын 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хурлаар баталсан Компанийн тухай хуулийн хэм хэмжээнд нийцүүлэн өөрчлөлт оруулсан шинэчилсэн найруулга бөгөөд компанийн үйл ажиллагаанд үүсэх аливаа харилцааг зохицуулах эрх зүйн үндсэн баримт бичиг болно.

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү Дүрмийн зорилт нь Тахько хувьцаат компанийн эрх зүйн байдлыг тодорхойлох, аж ахуйн үйл ажиллагааг явуулах, өөрчлөн байгуулах, компанийн удирдлага, зохион байгуулалт, хяналтын бүтэц, хувьцаа эзэмшигчдийн эрх, үүргийг тогтоох болон компанийг татан буулгах явцад үүсэх аливаа харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Тахько хувьцаат компани (товчилсноор «Тахько (ХК) компани» гэж нэрлэгдэх) нь Монгол улсын хуулийн хүрээнд аж ахуйн үйл ажиллагаа явуулж ашиг олох зорилготой өөрийн тусгаарласан хөрөнгөтэй (2011 оны жилийн эцсийн балансаар баталгаажсан), төрийн өмчийн оролцоогүй, хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, хувьцаа нь үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэгдэж, нийтэд чөлөөтэй арилжаалагддаг нээлттэй хувьцаат компани болно.
- 1.3. Компанийн албан ёсны нэрийг монголоор: Тахько хувьцаат компани, товчилсноор Тахько (ХК) компани, англиар Takhi joint stock company, товчилсноор Takhi JSC гэж нэрлэнэ.
- 1.4. Байршил нь: Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 5 дугаар хороо, Самбуугийн гудамж-18.
- 1.5. Компани хуулийн этгээдийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаа явуулах, хэлцэл хийх, гэрээ байгуулах, баримт бичиг үйлдэх зэрэг бүх тохиолдолд оноосон нэрний ард "ХК" гэсэн тэмдэглэгээг заавал хэрэглэнэ.
- 1.6. Компани нь Монгол улсын хууль тогтоомж, энэхүү дүрмээр тогтоосон эрх, үүрэг, хариуцлагын зарчмыг мөрдлөгө болгон ажиллаж өөрийн тайлан тэнцэл гаргаж, тамга, тэмдэг, албан бичиг хэрэглэх, тушаал гаргах эрх бүхий бие даасан хуулийн этгээд мөн болно.
- 1.7. Компани өөрийн нэрийн өмнөөс хэлцэл хийх, гэрээ байгуулах, аливаа хэлцэл, гэрээнд нэгдэн орох, өмч хөрөнгийн болон үйл ажиллагааныхаа талаар хуулиар олгогдсон эрх, үүрэг, хариуцлага хүлээж арбитрын байгууллага, шүүхэд нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцох эрхтэй байна.
- 1.8. Компани хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр хараат болон охин компани Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр салбар, төлөөлөгчийн газар байгуулж болно. Компанийн салбар, төлөөлөгчийн газар нь бие даасан хуулийн этгээдийн эрхгүй бөгөөд компаниас олгосон бүрэн эрхийн хүрээнд түүний нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулна. Салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаанаас үүсэх хариуцлагыг Компани хүлээнэ. Харин охин болон хараат компанийн үүрэг, хариуцлагыг хуульд зааснаас бусад тохиолдолд Компани хүлээхгүй.



- 1.9. Компани нь хөдөлмөрийн харилцааг зохицуулах Хөдөлмөрийн дотоод журамтай байх бөгөөд ажиллагчидтайгаа хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллана.
- 1.10. Компани нь бүртгэх байгууллагад бүртгэгдсэн өөрийн бэлэгдэл болон барааны тэмдэгтэй байж болох бөгөөд түүний загварыг Төлөөлөн удирдах зөвлөл батална.
- 1.11. Их хэмжээний ба сонирхолын зөрчилтэй хэлцэл, хараат болон охин компани, компанийн нэгдэл, хувьцааг нэгтгэх, хуваах, эд хөрөнгийн ба эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох, нэгдмэл сонирхолтой этгээд, тооллогын комиссын үйл ажиллагаа зэрэг энэ дүрмээр зохицуулахаар тусгагдаагүй аливаа асуудлыг Компанийн тухай хууль, бусад хууль тогтоомжид зааснаар зохицуулна.

## ХОЁР. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛГО, ЧИГЛЭЛ

- 2.1. Зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн ажил, үйлчилгээ явуулж, ажиллагсдын нийгмийн болон ахуйн хэрэгцээг бүрэн дүүрэн хангаж ажиллах замаар ашгийн хэмжээг нэмэгдүүлэх, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг дээдлэх, нийгмийн ашиг тусын тулд ажиллах нь компанийн эрхэм зорилго мөн.
- 2.2. Компанийн үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд дараах эрхийг эдлэнэ:
  - 2.2.1. Өөрийн болон гадны нөөц, боломжийг бүрэн ашиглах замаар экспортын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, чанар сайтай (өрсөлдөх чадвартай) төрөл бүрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж дотоод, гадаадын зах зээлд өөрөө шууд буюу бусад байгууллагаар дамжуулан худалдах;
  - 2.2.2. Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний үр ашиг, чанар, соёлыг байнга дээшлүүлэх, худалдан авагчдын хэрэгцээг хангах зорилгоор шинэ техник, технологи, зохион байгуулалт, удирдлага, үйлчилгээний дэвшилттэй арга сонгон компанийн ажилд байнга нэвтрүүлэх;
  - 2.2.3. Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ болон техник, технологийн хөгжил, зохион байгуулалтын цаг үеийн болон ирээдүйн шаардлагыг үндэслэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээлт, үйлдвэр, худалдаа, үйлчилгээний нэгжийг бүрэн буюу бүрэн бус хязгаарлагдмал хариуцлагатайгаар салбарлан байгуулах, өргөтгөх, жижигрүүлэх, хэсэгчлэн хуваах болон шаардлагатай тохиолдолд татан буулгах;
  - 2.2.4. Аж ахуйн нэгж шинээр зохион байгуулах, өргөтгөх, жижигрүүлэх, хэсэгчлэн хуваах, зохион байгуулалтын ба техник, технологийн төсөл боловсруулах, шаардагдах бусад баримт бичиг, зураг, төсөл, төсөв боловсруулж өөрийн болон захиалагч бусад байгууллагын хэрэгцээг хангаж ажиллах;
  - 2.2.5. Бусад аж ахуйн нэгжийн зээллэг, барьцаа, хувьцаа зэрэг үнэт цаас, өр, гэрээ хэлцлийн мөнгөн төлбөрийг төлөх замаар баталгаа гаргах, хувь хэмжээг эзэмших болон Монгол улсын ба гадаад орны банк болон бусад аж ахуйн байгууллагуудын үнэт цаасыг худалдан авах, эзэмших, худалдах, бусад компани, аж ахуйн нэгжид зээл олгох, авах зэрэг шууд ба шууд бусаар дотоод, гадаадын байгууллагуудад ашигтай төрөл бүрийн хэлбэрээр хөрөнгө оруулах;
  - 2.2.6. Мөнгөн төлбөрөө ихэсгэх эсвэл зээл авах, хөрөнгө төвлөрүүлэх болон бусад зорилгоор компанийн өмч хөрөнгийн зарим хэсгийг болон бүгдийг барьцаалах;
  - 2.2.7. Дотоод, гадаадын байгууллага, хүмүүст компанийн өмч хөрөнгийн зарим хэсгийг болон бүгдийг хугацаатай түрээслүүлэх, дотоод, гадаадад бусдын өмч хөрөнгийг түрээслэн буюу худалдан авч ашиглах;
  - 2.2.8. Гэрээ, хэлцлийн дагуу дотоод, гадаадын компани, аж ахуйн нэгжийн эрх, үүргийг хугацаатай буюу хугацаагүй хүлээх, тэдгээрийг төлөөлөх, өөрийн эрх, үүргийг хугацаатай буюу хугацаагүй шилжүүлэх, тэдгээрийн үнэт цаас, өмч хөрөнгийг



- худалдаж авах, түрээслэн авах, энэ зорилгоор компанийн өр, зээллэг, өмч хөрөнгийг хэсэгчлэн буюу бүхэлд нь худалдах, барьцаалах, солилцох болон бусад хэлбэрээр захиран зарцуулах;
- 2.2.9. Засгийн газар, аймаг, хот, дүүрэг, орон нутгийн захиргаа болон эрх мэдэл бүхий бусад газруудтай гэрээ, хэлцэл хийж өөрийн үйл ажиллагаанд давуу эрх, нөхцөл, зөвшөөрөл олж авах;
- 2.2.10. Компани болон гишүүд, ажиллагсадынхаа эрх ашгийг хамгаалах үүднээс дотоод, гадаадын байгууллага, эвсэл, холбоог дэмжин туслах, элсэн нэгдэх бөгөөд төрөл бүрийн тэтгэвэр, тэтгэмж, даатгал, тусламж, буяны үйлд хандив өргөх;
- 2.2.11. Компани нь төрөл бүрийн хувьцаа, баталгаа, облигац (өрийн бичиг), эрхийн бичиг зэрэг үнэт цаас гаргаж түүнийг шууд буюу өөр байгууллагаар дамжуулан арилжаалах, шилжүүлэх, барьцаалах зэрэг олон хэлбэрээр үнэт цаасны зах дээр ажиллах;
- 2.2.12. Дотоод, гадаадын аль ч байгууллагатай гэрээ, хэлцэл байгуулж захиалга авах, өгөх, барааг дамжуулан худалдах, экспорт, импорт, бараа солилцоо зуучлах болон дотоод, гадаадад бөөний ба жижиглэн худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үзэсгэлэн, яармаг зохион байгуулах зэрэг аж ахуйн бусад төрөл бүрийн ажил эрхлэх;
- 2.2.13. Компани дотоод, гадаадын байгууллага, компаниудтай харилцаагаа өргөтгөж үйлдвэрлэлийг хорших, техник, технологи, мэдээлэл, мэргэжилтэн, ажилчид солилцох, хамтран ажиллах, хамтарсан үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ зохион байгуулах, бусад зуучлах зэрэг шууд хамтын ажиллагааны ашигтай бүх хэлбэрүүдийг сонгон хэрэгжүүлэх замаар бүтээгдэхүүний үйлдвэрлэл худалдаа, үйлчилгээний хүрээг өргөтгөн орлогоо (ашиг) нэмэгдүүлж ажиллах арга замаа бусдын шахалтгүйгээр бие дааж сонгон ажиллах;
- 2.2.14. Эрдэм шинжилгээ, зураг төсөл, туршилт, сорилт, зохион бүтээх ажлыг бие дааж буюу дотоод, гадаадын байгууллагуудтай хамтран хийх, харилцан тохиролцсон нөхцлөөр шинжлэх ухаан, техникийн баримт, бичиг солилцох, боловсон хүчин бэлтгэх, тэдний мэргэжил, мэргэшлийг дээшлүүлэх ажил эрхлэх, түүнчлэн өөрийн үйл ажиллагаанд шаардагдах үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний бүх төрлийн патент, лиценз худалдан авах, худалдах, солилцох үйл ажиллагааг харилцан ашигтай хэлбэр, нөхцөлөөр хэрэгжүүлэх;
- 2.2.15. Экспорт, импортын зах зээл, бараа, ажил, үйлчилгээний эрэлт хэрэгцээ, үнийн түвшингийн судалгаа хийх, ажиллах хэлбэр, өөрт ашигтай зах зээлийг бусдын шахалтгүйгээр сонгох, шаардагдах түүхий эд, бараа, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, бусад зүйлээ компанид ашигтай зах зээлээс худалдан авах;
- 2.2.16. Дотоод, гадаадын санхүү, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний ямар ч байгууллага, компанид хөрөнгө оруулах, хөрөнгөө барьцаалах, солилцох, худалдах ажил эрхлэх;
- 2.2.17. Ашигтай бусад төрөл, хэлбэрийн ажлыг Монгол улсын болон гадаадын тухайн орны хуулийн хүрээнд эрхлэн явуулах;
- 2.2.18. Гэрээ, хэлэлцээрээр хүлээсэн үүргээ үнэнч шудрага, хугацаанд нь чанартай хэрэгжүүлэхийг компанийн үндсэн үүрэг гэж үзнэ.
- 2.2.19. Компанийн эрх ашгийг хамгаалах зорилгоор хууль зүйн үндэслэл бүхий маргаантай аливаа асуудлыг дотоод, гадаадын мэргэжлийн болон хууль эрхийн байгууллагад шилжүүлж Монгол улсын хууль, олон улсын хэлэлцээрийн хүрээнд шийдвэрлүүлж ажиллана.
- 2.3. Компани Монгол улсын хууль тогтоомжийн дагуу байгаль орчныг хамгаалж ажиллана.



- 2.4. Компани нь хуулиар хориглоогүй ямар ч үйл ажиллагаа эрхлэн явуулж болох бөгөөд энэхүү дүрэм хүчин төгөлдөр болсон үеэс дараах үйл ажиллагааг эрхлэн явуулна. Үүнд:
- 2.4.1. Үл хөдлөх хөрөнгийн түрээс, үйлчилгээ
- 2.4.2. Гадаад дотоод худалдаа, хөрөнгө оруулалт

### ГУРАВ. КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, ХУВЬЦАА, ҮНЭТ ЦААС

- 3.1. Компаниас хувьцаа эзэмшигчдэд эзэмшүүлсэн буюу гаргасан нийт давуу эрхийн болон энгийн хувьцааны нэрлэсэн үнийн дүнг компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө гэнэ. Хувь нийлүүлсэн хөрөнгөд зарласан болон эргүүлэн худалдаж авсан халаасны хувьцаа хамаарахгүй.
- 3.2. Компанийн балансад тусгагдсан биет болон биет бус хөрөнгийн дүнгээс компанийн нийт өр төлбөрийг хасаад үлдсэн хэсгийг компанийн өөрийн хөрөнгө гэнэ.
- 3.3. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь компанийн өөрийн хөрөнгийн хэмжээнээс илүүгүй байна.
- 3.4. Хувьцааг Компани худалдан авсан тохиолдолд уул (халаасны) хувьцаа нь саналын эрхгүй байх бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийг тодорхойлоход тооцогдохгүй, түүнд ногдол ашиг хуваарилахгүй. Нэг жилийн дотор худалдан борлуулаагүй халаасны хувьцааг Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр цуцалж, хувьцаа эзэмшигчдийн эзэмшилд үлдсэн бүх хувьцааны нийлбэрийг 100 хувь гэж үзнэ.
- 3.5. Компани нэг бүр нь 168 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 3,000,000 ширхэг энгийн хувьцаа гаргах эрхтэй. Компани нь хууль тогтоомжид заасан нөхцөл, журмын дагуу давуу эрхийн хувьцаа гаргаж болно.
- 3.6. Компани зарласан хувьцааныхаа тоонд багтаан нэрлэсэн үнээс нь багагүй үнээр энгийн хувьцаа гаргана. Энэ дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах өдрийн байдлаар эргэлтэд байгаа (гаргасан) нийт хувьцааны тоо 1,189,983 ширхэг байгаа бөгөөд компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн үнийн дүн нь 199,917,144 төгрөг байна.
- 3.7. Зарласан хувьцааны тоог нэмэгдүүлэх шаардлага гарвал хувьцаа эзэмшигчдийн хурлаас компанийн дүрэмд өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэнэ. Хувьцааны зах зээлийн үнэ нь нэрлэсэн үнээс өөр байж болно.
- 3.8. Төлөөлөн удирдах зөвлөл нь тухайн жилийн санхүүгийн тайлангаар компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс багассан тохиолдолд уг тайлан гарснаас хойш ажлын 10 өдрийн дотор хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлаж, хувь нийлүүлсэн хөрөнгөд өөрчлөлт оруулах, компанийг дахин хөрөнгөжүүлэх, эсхүл татан буулгах асуудлыг шийдвэрлүүлэнэ.
- 3.9. Дүрмийн 3.5-д заасан зарласан хувьцаанаас үйлдвэрлэл, үйлчилгээг өргөтгөх, шинэчлэх, нэмэгдэл хөрөнгийн эх үүсвэр бий болгох зорилгоор энгийн хувьцаа нэмж гаргах асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэнэ.
- 3.10. Компани нь нээлттэй буюу хаалттай захиалгын үндсэн дээр хувьцаа болон бусад төрлийн үнэт цаас гаргаж болно.
- 3.11. Компанийн энгийн хувьцаа худалдан авах эрхийн бичиг болон хувьцаанд хөрвөх үнэт цаас, опционыг гаргах, худалдах шийдвэр, нөхцөл, журмыг Төлөөлөн удирдах зөвлөл гаргана.